



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2021 оны 08 сарын 25 өдөр

Дугаар А/200

Улаанбаатар хот

Сургалтын үйл ажиллагаанд
зохицуулалт хийх тухай

Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9 дэх заалт, Засгийн газрын 2020 оны “Боловсролын салбарт хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 32 дугаар тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн “Түр журам шинэчлэн батлах тухай” А/290 тоот тушаал, МУИС-ийн дүрмийн 4.3.1 дэх хэсэг, Захиргааны зөвлөлийн 2021 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн хурлын тэмдэглэл, шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. 2021-2022 оны хичээлийн жилийн намрын улирлын сургалтыг 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс танхимын бус /цахим/ хэлбэрээр, 09 дүгээр сарын 13-ны өдрөөс танхимын болон танхимын бус хосолсон хэлбэрээр сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу зохион байгуулсугай.

2. Сургалтын үйл ажиллагаанд зохицуулалт хийх удирдамжийг хавсралтаар баталсугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сургалт, оюутан хариуцсан дэд захирал /Д.Бадмаанямбуу/, Захиргаа, хүний нөөцийн газрын дарга /Г.Мөнхбаяр/, Мэдээллийн технологийн газрын дарга /А.Баатарбилэг/, бүрэлдэхүүн сургуулийн захирал /Д.Заяабаатар, Д.Бямбажав, Б.Амарсанаа, Ч.Энхбаяр, С.Баттулга/, салбар сургуулийн захирал /Т.Энх-Амгалан, Д.Алтанхуяг/ нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ОЧИРХУЯГ

Захирлын 2021 оны... дугаар сарын ... -ны
өдрийн... дугаар тушаалын хавсралт



СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗОХИЦУУЛАЛТ ХИЙХ УДИРДАМЖ

НЭГ. Элсэлт, шилжилтийн үйл ажиллагаатай холбоотой
зарим зохицуулалт

1.1. Элсэлт

- Бүх төрлийн (бакалаврын өдөр, орой, эчнээ, магистр, доктор, гадаад оюутан) хөтөлбөрт элсэгчдийн бүртгэл, элсэлтийн шалгалт, чиглүүлэх сургалтыг цахимаар зохион байгуулна.

1.2. Хөтөлбөр шилжилт

- Хөтөлбөр шилжилтийн бүртгэл, шилжилтийн шалгалт, шалгалтанд тэнцсэн бүртгүүлэгчийн бүртгэлийг цахимаар зохион байгуулна.

ХОЁР. Сургалтын үйл ажиллагаатай холбоотой
зарим зохицуулалт

2.1. Сургалтын үйл ажиллагаа

2021-2022 оны хичээлийн жилийн намрын улирлын хичээлийг дараах байдлаар сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу зохион байгуулна. Үүнд:

- 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 09 дүгээр сарын 10-ныг дуустал лекц, семинарын хичээлийг танхимын бус /цахим/ хэлбэрээр;
- 09 дүгээр сарын 13-ны өдрөөс холимог хэлбэрээр буюу 40 болон түүнээс дээш суралцагчтай хичээлийн лекцийг цахимаар, 39 болон түүнээс доош суралцагчтай хичээлийн лекц болон семинарыг танхимын хэлбэрээр;
- Лабораторийн хичээлийг 09 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлэн 20-оос илүүгүй суралцагчтайгаар, хоцрогдсон агуулгыг багтаан танхимын хэлбэрээр зохион байгуулна.
- Цахимаар орох хичээлийн бичлэг болон холбогдох материалыг Microsoft Teams платформд хуваарьт цагт багтаан байршуулна.
- Холимог сургалтын хугацаанд бага талбайтай танхимд орох хуваарь бүхий хичээлийг талбай томтой танхимд шилжүүлэн сургалтыг явуулна.
- Ахисан түвшний сургалтыг шууд болон шууд бус хэлбэрээр цахимаар зохион байгуулна.
- Монгол хэлний сургалтыг танхимаар болон цахимаар зохион байгуулна.

- Гадаадад байгаа гадаад оюутны бакалаврын сургалтыг бүлэг бүрдсэн нөхцөлд цахимаар зохион байгуулна.
- Сургалтыг цахимаар зохион байгуулахдаа дараах зүйлсийг баримтална. Үүнд:
 - Microsoft Teams платформыг сургалтын үндсэн платформ болгон ашиглаж, хичээлийг дараах 2 хэлбэрийн аль нэгээр зохион байгуулна. Үүнд:
 - А. Хичээлийн хуваарьт цагт шууд цахим /синхрон/-аар хичээл орж, хичээлийн бичлэгийг платформд байршуулах
 - Б. Хичээлийн хуваарьт цагт урьдчилан бэлтгэсэн видео агуулгыг платформд байршуулж хичээлийн дараагийн оролт хүртэл хэлэлцүүлэг хийх
 - Online.num.edu.mn (Open EdX) сургалт удирдлагын системд бүртгүүлсэн цахим хичээлийг тухайн платформоор орж болно. Энэ тохиолдолд Microsoft Teams платформ ашиглахыг шаардахгүй.
 - Цахимаар явагдах сургалтын хувьд суралцагчийг заавал тухайн цагт сургалтад оролцохыг шаардахгүй бөгөөд суралцагчийн ирц, оролцоог хэрхэн бүртгэх, дүгнэхийг сургалтыг удирдаж буй багш шийдвэрлэнэ.
 - Цахим хичээлийн материалыг хичээлийн улирал дуустал платформд байршуулна.
 - Цахим хичээлд хамаарах даалгавар нь цахимаар олох боломжтой материал, ном, сурах бичгийн хүрээнд байна.
- Сургалтын явцын санал асуулгыг улирлын 3-4 дэх долоо хоногт зохион байгуулж, тухайн хичээлийг сонгосон идэвхитэй суралцагчдын олонхи нь сургалтын чанар хангалтгүй гэж үзвэл тухайн хичээлийг цуцална. Хичээл цуцалсан тохиолдолд суралцагчийн тухайн хичээлийн багц цагийн төлбөрийг бүрэн буцаан олгоно. Суралцагч тухайн хичээлийг зааж байгаа өөр багшийн хичээлд шилжин суралцаж болно. Цуцлагдсан хичээл заасан багшид тухайн хичээлийн сургалтын А цагийн ноогдол олгохгүй.

2.2. Дүнгийн гомдол, маргаан

- Дүнгийн маргаан, гомдлын өргөдлийг 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 02-ны өдрийг хүртэл шийдвэрлэнэ. Суралцагч дүнгийн гомдол маргааны өргөдлийн маягтыг бөглөн багшид цахимаар илгээх ба багш маягтыг баталгаажуулан багшийн ажлын дэвтэр, шалгалтын хуудас гэх мэт холбогдох материалын хамт Элсэлт, бүртгэлийн хэлтсийн дүн бүртгэл хариуцсан мэргэжилтэнд өгч дүнг оруулна.

2.3. I, E үнэлгээтэй хичээл

- Өмнөх улиралд бүрэн дүгнэгдээгүй I, E үнэлгээтэй хичээлийн нөхөн шалгалтыг 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 02-ны өдрүүдэд багш цахимаар зохион байгуулж, үнэлгээг системд оруулна.

2.4. Шалгалт

- Явцын болон улирлын шалгалтыг цахимаар эсвэл танхимд 40 хүртэл хүнтэйгээр зохион байгуулж болно.
- Төгсөлтийн нэгдсэн шалгалт, судалгааны ажлын урьдчилсан болон жинхэнэ хамгаалалт, дадлага ажлын хамгаалалтыг 40 хүртэл хүнтэйгээр танхимд зохион байгуулж болно.

2.5. Биеийн тамирын хичээл

- 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 09 дүгээр сарын 13-ны өдөр хүртэл цахимаар орох бөгөөд 09 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлэн цахим болон спорт зааланд (хамгийн ихдээ 40 хүнтэй байхаар) хосолсон байдлаар хичээллэнэ.

2.6. Дадлага

- Тэнхимийн саналаар мэргэших, багшлах, үйлдвэрлэлийн дадлагыг холбогдох газруудад 40-өөс илүүгүй хүнтэй байхаар зохион байгуулна.
- Өмнөх улиралд цуцлагдсан хээрийн болон танилцах дадлагыг 40-өөс илүүгүй хүнтэй байхаар зохион байгуулах ба 9 дүгээр сард зайлшгүй хийх шаардлагатай, намрын улирлын сургалтын үйл ажиллагаанд саад болохгүй хийх боломжтой хээрийн дадлагыг тэнхимээс гаргасан санал, удирдамжийн дагуу тухайн орон нутагт нь ганцаарчлан дадлага хийлгэнэ.

ГУРАВ. Оюутны дотуур байртай холбоотой зарим зохицуулалт

- 3.1. Оюутны дотуур байранд суух бүртгэлийг 09 дүгээр сарын 06-ны өдрөөс 09 дүгээр сарын 09-ний өдрүүдэд СИСИ системээр зохион байгуулна.
- 3.2. Дотуур байранд суух бүртгэл нь баталгаажсан оюутан, суралцагчийг 09 дүгээр сарын 11-ний өдрөөс дотуур байранд суулгана.